# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр Дугаар А/551 Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 12 нэр төрлийн нийт 4,873,131.15 (дөрвөн сая найман зуун далан гурван мянга нэг зуун гучин нэгэн төгрөг арван таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэг (А.Энхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 9 нэр төрлийн 2,497,671.15 (хоёр сая дөрвөн зуун ерэн долоон мянга зургаан зуун далан нэгэн төгрөг арван таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 3 нэр төрлийн 2,375,460.00 (хоёр сая гурван зуун далан таван мянга дөрвөн зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэг (А.Энхцэцэг)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1150501685

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12. дугаар сарын 10. -ны өдрийн A/551 дугаар тушаалын хавсралт

## Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 127 дугаар цэцэрлэг

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | байгууллагын санал | мэргэжилтний санал | ҮХХХК-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.Тавилга эд хогшил | | | | | | | | | | | | | |
| 1 | Хивс | 10 | ш | 1 | 433,640.00 | 433,640.00 | 433,640.00 | - | эвдэрсэн | актлах | 2,000 | татах | |
| 2 | Дрож | 10 | ш | 1 | 1,221,820.00 | 1,221,820.00 | 1,221,820.00 | - | эвдэрсэн | актлах | 5,000 | татах | |
| 3 | Хүүхдийн ширээ | 10 | ш | 5 | 62,000.00 | 310,000.00 | 310,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 4 | Багш ширээ | 10 | ш | 1 | 65,000.00 | 65,000.00 | 65,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 5 | Багш сандал | 10 | ш | 1 | 18,000.00 | 18,000.00 | 18,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 6 | Хувцасны шүүгээ | 10 | ш | 2 | 280,000.00 | 560,000.00 | 560,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 7 | Хөнжил гудасны шүүгээ | 10 | ш | 1 | 165,000.00 | 165,000.00 | 165,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 8 | Номын тавиур | 10 | ш | 1 | 75,000.00 | 75,000.00 | 75,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 9 | Тавиур / хичээлийн хэрэгсэл/ | 10 | ш | 2 | 165,000.00 | 330,000.00 | 330,000.00 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 10 | Хувцасны шүүгээ | 10 | м | 4 | 152,386.70 | 609,546.80 | 609,546.80 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 11 | Эмнэлгийн булан | 10 | ш | 1 | 365,124.35 | 365,124.35 | 365,124.35 | - | эвдэрсэн | актлах | 1,000 | устгах | |
| 12 | Шатны хивс | 10 | м | 20 | 36,000.00 | 720,000.00 | 720,000.00 | - | эвдэрсэн | актлах | 10,000 | татах | |
| Тавилга эд хогшлын үнэ | | | | | | **4,873,131.15** | **4,873,131.15** | | | | **27,000** | | |
| **Нийт дүн** | | | | | | | | | | | | | |
| Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө | | | | | | | | | | | | | |
| Татан төвлөрүүлэх | | | | | | 2,375,460.00 | | | | | | | |
| Устгах хөрөнгө | | | | | | 2,497,671.15 | | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/ | | | | | | | | | | | | | |